

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтад “ТӨ-IVA” адилтгах албан тушаалын зэрэглэлд “Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хорооны дарга,” гэж, “ТӨ-VA” адилтгах албан тушаалын зэрэглэлд “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хорооны гишүүн,” гэж тус тус нэмсүгэй.

2.Тус хавсралтын “ТӨ-VA” адилтгах албан тушаалын зэрэглэлээс “Шүүхийн сахилгын хорооны дарга,” гэснийг, “ТӨ-VIA” адилтгах албан тушаалын зэрэглэлээс “Шүүхийн сахилгын хорооны гишүүн,” гэснийг тус тус хассугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Цалин, нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.9, 76.10 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, 57.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын цалингийн 40 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүнийг олгох журам”-д заасан хувиар, докторын зэргийн нэмэгдлийн хэмжээг мөн тогтоолын 2-т заасан хувиар тус тус тогтоосугай.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүнийг томилсон өдрөөс нь эхлэн цалин, нэмэгдлийн хэмжээг тооцон олгосугай.

4.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын 2022 оны ... дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга /шүүгч бус гишүүн/	3.200.000
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн	3.000.000

---o0o---

Монгол Улсын Их Хурлын 2022 оны ... дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Шүүхийн сахилгын хорооны дарга /шүүгч бус гишүүн/	3.200.000
2	Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн	3.000.000

---o0o---